

## Монгол бичгийн хэлний найруулга дахь манж хэлний нөлөө

М. Баярсайхан (Осака Их сургууль)

Монгол хэлнээс манж, жүрчин хэлэнд орсон үг, монгол бичгийн соёл манжид хэрхэн нөлөөлсөн талаар цөөнгүй судалгаа гарчээ. Харин манж хэлний нөлөө монгол хэлэнд хэрхэн туссан талаар судалгаа харьцангуй бага бөгөөд манж хэлнээс монгол хэлэнд орсон үгсийн талаар цөөн тооны багахан өгүүлэл гарснаас цааш төдий хэтэрсэн зүйлгүй байна. Хэлний харилцан нөлөөлөл үгийн сангийн түвшнээс гадна найруулгын түвшинд тохиолдох нь ялангуяа бичгийн хэлэнд түгээмэл байна.

Энэ илтгэлд миний бие монгол бичгийн хэлний найруулга дахь манж хэлний нөлөө тусгалын талаар өөрийн зарим ажиглалтыг дурдлаа. Чин улсын үед монгол албан бичгийн хэлэнд манж бичгийн хэл болон манжаар дамжуулан хятад албан бичгийн хэлний нөлөө туссан нь нэгэнтээ тодорхой асуудал юм. Зөвхөн албан бичиг төдийгүй сургаалын зохиолд ч манж хэлээрх сургаалын зохиолын нөлөө мэдэгдэхүйц туссан байдаг. Үүнд, ялангуяа 20-р зууны эхэн үеийн монгол сургаалын зохиолуудыг дурдаж болно.

1930-иод оны үеэс тэрхүү хуучин албан бичгийн хэлний найруулга, үг хэллэг үндсэндээ орхигдсон юм. Гэвч манж хэлний нөлөөгөөр монгол бичгийн хэлэнд нэвтэрсэн зарим үг, хэллэг одоо ч бичигт болон ярианд хэвшин тогтсон хэвээр байгаа бөгөөд заримыг нь манж хэлний нөлөөгөөр орж ирсэн гэдгийг үл анзааран сонгодог бичгийн хэлнээс уламжилсан зүйл гэж ойлгосоор иржээ. Энэ нь, манж монгол хоёр хэл үг зүй болон өгүүлбэрийн хэв шинжийн хувьд адилхан бүтэцтэй, үгийн санд нь ч нийтлэг үгс нэлээд байдаг тул харилцан ялгаатай зүйлийг ялгаж танихад бэрх байдагтай холбоотой юм. Манж хэлний нөлөөг дараах хэдэн зүйлд хуваан үзэж болмоор байна.

1. Манж хэлнээс орсон (зээлдсэн) үгс. Миний нягталснаар манж хэлнээс монгол хэлэнд орсон гэж үзэх 100 гаруй үг байна. Эдгээр нь ихэвчлэн нийгэм улс төрийн нэр томьёо шинжтэй хуучирсан үг боловч, “*бодох, хачин, хошой...*” г.м яриа, бичгийн аль алинд идэвхтэй хэрэглэгдсээр буй. Энэ талаар үүнээс өмнө илтгэл хэлэлцүүлж байсан учир энэ удаа давхардуулж дэлгэрэнгүй ярихгүй.

2. Үгчилсэн орчуулгаар дамжин зарим үг ба хэллэгийн хэрэглээ, давтамж нь ихэссэн буюу багассан байна. Жишээлбэл: Чингийн үеэс өмнө идэвхтэй хэрэглэгдэж байсан *сааргүй* хэмээх үг маш бага хэрэглэгдэх болж үүний оронд *эрхбиш, эрхгүй (urunakū)* гэдэг үгийг түгээмэл хэрэглэх болжээ.

3. Манж хэлний нөлөөгөөр зарим үгийн утга хувирсан байна. Жишээлбэл: манж хэлний *ba* гэдэг үгийн орчуулгын улмаас монгол хэлний *газар* гэдэг үгэнд явдал гэсэн утга нэмэгдэж, салаа утгатай болжээ.

4. Манж монгол толь бичгийг анх зохиож толилох үед толь тусгасан манж хэлний нөлөө бүхий монгол үгс. Жишээлбэл: монгол хэлний *аж төрөх* гэдэг холбоо үг бол манж хэлний *banjimbi* гэдэг үгийн үгчилсэн орчуулга болж анх толь бичигт тусгаснаас хойш өргөн хэрэглэгдэх болжээ. Манж монгол уламжлалт толь бичгүүдээс өмнө энэ үг төдийлөн хэрэглэгдэж байсангүй.

5. Монгол хэлэнд байгаагүй үг зүйн хэлбэржилт манж хэлнээс орж ирсэн тохиолдол байна. Жишээлбэл: аливаа юмыг бүтсэн эд махбодоор нь зааж тодотгоход монгол хэлэнд шууд үгийн үндсээр холбож тодотгодог байхад манж хэлэнд харьяалахын тийн ялгалын *-i, ni* нөхцөлөөр хэлбэржүүлдэг. Тэгвэл монгол утга зохиолд “*хасын царай*” г.м дүрслэл тохиолддог нь манж хэлний нөлөө юм.

Энэ хоёр хэлний найруулгыг харьцуулж, харилцан нөлөөллийг судлах нь харьцуулсан хэлшинжлэлд төдийгүй, сурвалж судлалд тухайлбал, он цаг нь үл мэдэгдэх аль нэг орчуулгын зохиол хэдий үеийнх вэ гэдгийг багцаалахад тус нэмэр болох юм.